



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2017 оны 08 сарын 31 өдөр

Дугаар 5/99

Чингис хот

Ажилд шилжүүлэн томилох тухай

Төрийн албаны тухай Монгол Улсын хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалт, “Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын даргын тушаал гаргах журам /код-136/”-ийн 136.4.2-ийн “б” заалт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дүгээр тушаалаар батлагдсан “Алба хаагчийг шилжүүлэн ажиллуулах журам /код-908/”-ын 908.2.2-ийн “а” заалт, цагдаагийн газрын даргын зөвлөлийн 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн ээлжит 15 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн ахлах ахлагч Б.Ханхүүг Бор-Өндөр сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн Галшар сум дахь цагдаагийн үүрэгт ажлаас 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлж, 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс Биндэр сум дахь сум дундын цагдаагийн тасагт Дадал сум дахь цагдаагаар шилжүүлэн томилсугай.

2. Цагдаагийн ахлах ахлагч Б.Ханхүүгийн албан тушаалын үндсэн цалинг Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 332 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан цалингийн шатлалын ТТ-7-2 дугаар шатлал 503874 төгрөгөөр, цолны нэмэгдлийг 25 хувиар, онцгой нөхцөлийн нэмэгдлийг 25 хувиар, алба хаасны нэмэгдэлийг 10 хувиар тус тус бодож олгохыг ахлах нягтлан бодогч, цагдаагийн хошууч Ж.Баатарт зөвшөөрсүгэй.

3. Шилжин томилогдсон цагдаагийн ахлах ахлагч Б.Ханхүүгийн ажлын байрыг хүлээлцүүлэх, албан тушаалтай нь холбоотой хууль, дүрэм, журам, эрх зүйн актуудыг танилцуулан судлуулах, мөрдүүлэх, цаг ашиглалт, сахилга ёс зүйн байдалд тогтмол хяналт тавьж, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дасан зохицох хөтөлбөр хэрэгжүүлэх журам /код-912/-ын дагуу богино хугацаанд ажилд нь сургаж дадлагажуулан биелэлт үр дүнг тооцож ажиллахыг Биндэр сум дахь сум дундын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Г.Отгонжаргалд даалгасугай.

4. Тушаалын хуулбарыг хувийн хэрэгт нь хавсаргахыг Хүний нөөцийн мэргэжилтэн, цагдаагийн ахмад П.Алтантуяад үүрэг болгосугай.

5. Тушаалыг нийт бүрэлдэхүүнд танилцуул.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА



Ж.БОЛД